



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/58

Жаргалтхаан

**Ойн сан бүхий газарт зорчих
хөдөлгөөнийг түр зогсоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.4, 18.2.12, 18.2.14 дэх заалт, Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ойн сан бүхий газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд, ойн нөхөрлөлүүд, мод бэлтгэх, дагалт баялаг ашиглах зорилгоор зорчих хөдөлгөөнийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл түр зогсоосугай.

2.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, эргүүл харуулыг томилон ажлуулахыг ойн нөхөрлөлийн ахлагч нарт үүрэг болгосугай.

3.Ойн нөхөрлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, захирамжийг иргэдэд сурталчлан гүйцэтгэлийг хангуулан, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Түмэнжаргалд, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ